



## ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН УНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот

“Цусаа бэлэглэж эв нэгдлийг эрхэмлэн,  
бусдын амь насыг аварцгаая”  
аян зарлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. дахь заалт, Донорын тухай хуулийн 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цусаа бэлэглэж эв нэгдлийг эрхэмлэн, бусдын амь насыг аварцгаая” 21 хоногийн аяны удирдамжийг 1 дүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Удирдамж, төлөвлөгөөний дагуу Цусны салбар төвүүд хариуцсан нутаг дэвсгэртээ тус аяныг зохион байгуулж, тайлан ирүүлэхийг Цусны салбар төвийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга /А.Амарзаяа/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

1118266548 Ө.0216905

080193

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 6 дугаар сарын 09. -ны  
өдрийн 13 дугаар тушаалын  
1 дүгээр хавсралт

“ЦУСАА БЭЛЭГЛЭЖ ЭВ НЭГДЛИЙГ ЭРХЭМЛЭН, БУСДЫН АМЬ НАСЫГ  
АВАРЦГААЯ”

21 ХОНОГИЙН АЯНЫ УДИРДАМЖ

**Нэг. Үндэслэл**

Жил бурийн 6 дугаар сарын 14-нд “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэдэг бөгөөд энэхүү өдрийн гол зорилго нь аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний амин чухал хэсэг болох цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамж, авлагагүй сайн дурын цусны донорын хөдөлгөөнийг олон нийтэд улам бүр таниулан сурталчлаад оршдог.

Хэдийгээр коронавируст халдвартын цар тахлын нөхцөл байдал намжмал байдалд орсон хэдий ч багагүй хугацааны хөл хорио, тусгаарлалтын дараа иргэдийн зорчих хөдөлгөөн ихсэхтэй холбогдуулан цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс хувь хүн, нийгэм, олон нийт, хамтрагч байгууллагуудад хандсан цус цуглуулалтын 21 хоногийн аяныг зохион байгуулж байна.

**Хоёр. Зорилго**

Улирлын хамааралтай цусны нөөц буурахаас урьдчилан сэргийлэх, авлагагүй сайн дурын цусны донорын үйлсийг сурталчлан таниулах

**Гурав. Зорилт**

Авлагагүй, сайн дурын цусны донорын үйлсийг олон нийтэд сурталчлах ажлыг идэвхжүүлэх

Хүн амын цусны донорын талаарх мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах

**Дөрөв. Хэрэгжих хугацаа**

2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 7 дугаар сарын 4-ний өдрийг хуртэл

**Тав. Аяны санхүүжилт**

Аяныг зохион байгуулаад шаардлагатай санхүүжилтийг байгууллагын төсөв, МУЗН, Эрүүл мэндийг дэмжих сан, хандивлагч байгууллагын хандиваар санхүүжүүлнэ.

**Зургаа. Хамтран хэрэгжүүлэх байгууллага**

Эрүүл мэндийн яам, МУЗН, Эрүүл мэндийг дэмжих сан, Төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн, хамт олон

**Долоо. Хүлээгдэж буй үр дүн**

Хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг, хандлага, дадал сайжирна.

Улирлын хамааралтай цусны нөөц буурахаас сэргийлж, цусны нөөцийг зохист түвшинд хүргэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 6 дугаар сарын 09. -ны  
өдрийн 11/2 дугаар тушаалын  
2 дугаар хавсралт

1118266548 +9126905

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ахлагч:  
А.Амарзаяа /Цусны чанар, аюулгүй байдлын албаны  
дарга/
- Гишүүд:  
Д.Дулмаа /Маркетинг, нийгмийн эрүүл мэндийн  
ажилтан/  
Р.Энхтуяа /Маркетинг, олон нийттэй харилцах  
менежер/  
Б.Ижилбаатар /Донор зохион байгуулалтын тасгийн  
их эмч/  
Ц.Мөнхшүр Донор зохион байгуулалтын тасгийн их  
эмч/  
Б.Буяントогтох /Донор зохион байгуулалтын тасгийн  
сувилагч/  
Х.Чулуунцэцэг /Донор зохион байгуулалтын тасгийн  
сувилагч/  
Х.Гунгаанаран /ЭШМТА-ны Мэдээллийн технологийн  
инженер/  
Ч.Тунгалаг /Донор зохион байгуулалтын тасгийн  
эрхлэгч/
- Нарийн бичиг:

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын  
2022 оны 6 дугаар сарын 09. -ны  
өдрийн 4/2 дугаар тушаалын  
3 дугаар хавсралт

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч	Шаардагдах нөөц
1	Аяны үйл ажиллагааг олон нийтэд зарлах	6 сарын 13	А.Амарзаяа	Цусны салбар төв	-
2	Стэнд, аннонс, зургийн хүрээ хэвлүүлэх	6 сарын 10-11	Х.Гунгаанааран, Б.Буянтогтох	СБА, цусны салбар төв	300,0
3	Хамтран ажиллагч байгууллагуудыг сурталчлах, аяны талаар хэвлэлийн мэдээлэл бэлтгэж, түгээх	Аяны турш	Р.Энхтуяа Д.Дулмаа	Цусны салбар төв	-
4	Цусаа бэлэглэх чөлөнж зохион байгуулах /фэйсбүүкийн группүүд/	Аяны турш	Ч.Тунгалаг Р.Энхтуяа Х.Чулуунцэцэг	Цусны салбар төв	-
5	Олны танил хүмүүсийг цусаа бэлэглэх үйлсэд татан оролцуулах /сайн дурьинхныг оролцуулах/	Аяны турш	Ажлын хэсэг	МУЗН	-
6	Явуулын станц ажиллуулах /асуулт хариулт, бэлэг түгээх/	7 хоногт 1удаа	Х.Чулуунцэцэг Ц.Шүрээ Х.Гунгаанааран	Цусны салбар төв	150,0
7	Аяныг нийтэд сурталчлах	Аяны турш	А.Амарзаяа	Цусны салбар төв	-